ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ · 2025 оны 6-р сарын 25

Г.АРИУНЗУЛ: ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ УДАА ДАРАА ҮЙЛДЭГДЭЖ БУЙ БААР, ШӨНИЙН ЦЭНГЭЭНИЙ ГАЗРУУДАД ПРОКУРОРЫН МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЖ, НЭР БҮХИЙ ГАЗРУУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦЛАХ САНАЛЫГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭЭД БАЙНА



Нийслэлийн Баянгол дүүрэг нь хүн амын нягтаршил ихтэй, худалдаа, үйлчилгээний газрууд ихээр төвлөрсөн нийслэлийн томоохон дүүрэг бөгөөд тэр хэрээр гэмт хэрэг, зөрчил их гардаг байна. Баянгол дүүргийн прокурорын газраас гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудад шалгалт хийсэн байна. Энэ талаар тус прокурорын газрын хяналтын прокурор Г.Ариунзулаас тодрууллаа.



Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийн хэдэн хувь нь баар цэнгээний газарт үйлчлүүлж буй иргэдээс ирдэг вэ? Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хэчнээн баар, цэнгээний газруудад шалгалт хийсэн бэ?

Дүүргийн цагдаагийн газарт 2024 онд иргэд, байгууллагаас гаргасан нийт 29841 гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн 54 хувийг гэмт хэргийн талаар, 46 хувийг зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна. Тодруулбал, зөрчлийн шинжтэй 13717 гомдол, мэдээллийн 339 нь, гэмт хэргийн талаарх 16124 гомдол мэдээллийн 608 нь диско клубт буюу баар, цэнгээний газарт үйлдэгдсэн талаарх дуудлага, мэдээлэл байсан.

Шалгалтыг гэмт хэрэг, зөрчил гарсан талаар дуудлага, мэдээлэл хамгийн их бүртгэгдсэн нэр бүхий 15 шөнийн цэнгээний газрыг сонгож хийсэн.

Ингэхдээ баар, цэнгээний газрууд нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дугаартай тогтоолоор баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй эсэх, аж ахуйн нэгж, байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг явуулж байгаа эсэхийг шалгасан.

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж буй газрууд хаана байна вэ?

Тус дүүргийн 5, 7, 12, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг баар, цэнгээний газруудад гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хамгийн ихээр бүртгэгдсэн байна. Тухайлбал, 12 дугаар хороонд үйл ажиллаагаа явуулдаг нэр бүхий цэнгээний газарт үйлдэгдсэн гэх 99 гомдол, мэдээлэл Цагдаагийн байгууллага

хүлээн авч шалгаснаас 25 нь зөрчлийн шинжтэй, 74 нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл байсан.

Баар, цэнгээний газруудад ихэвчлэн ямар төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байна вэ?

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд хамгийн их гарч байна. Тухайлбал; Шалгалт явуулсан нэр бүхий 15 шөнийн цэнгээний газарт гарсан нийт 480 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шинжтэй 278, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн шинжтэй 202 гомдол, мэдээлэл байна.

Баар, цэнгээний газраас үйлчлүүлж буй иргэд нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусадтай маргалдаж, улмаар хүний биед хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулах тохиолдол дийлэнхдээ гарч байна. Мөн банкны карт, гар утас болон бусад эд зүйлээ хулгайд алдах, бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх зэрэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг зонхилон үйлдэгдэж байна.

Хүний эрүүл мэндэд хохирол учруулах болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд шөнийн цэнгээний газруудад их гардаг юм байна. Хэргийн шийдвэрлэлт ямар байна вэ?

2024 оны байдлаар тус дүүргийн нутаг дэвсгэрт шөнийн цэнгээний газруудад үйлдэгдсэн нийт 608 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсанаас 278 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 21 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 260 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, мөрдөн байцаалтын 49 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, үүнээс 38 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 31 хүн хохирсноос 4 хүнд хүндэвтэр, 27 хүнд хөнгөн хохирол учирсан. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд зааснаар 21 нас хүрээгүй, эсхүл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглодог. Гэвч зарим шөнийн цэнгээний газрууд нь энэхүү хуулийн заалтыг зөрчиж 21 насанд хүрээгүй хүнд үйлчилснээр 20 настай 3 хүн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хохирол учрахаас гадна сэтгэл зүйд хохирол учирдаг. Сүүлийн үед сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой болсон. Энэ чиглэлээр хэрхэн ажиллаж байна вэ?

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад төлүүлнэ” гэж заасны дагуу прокурор эрүүгийн хэрэгтэй нь хамтатган шийдвэрлүүлж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалан ажиллаж байна.

> Тодруулбал, гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авдаг. Тэрхүү тусламж үйлчилгээ тухайн үедээ үнэ төлбөргүй мэт байх боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөгдөж байдаг гэсэн үг юм. Тиймээс 2024 онд зөвхөн шөнийн цэнгээний газар буюу бааранд үйлдэгдсэн гэмт хэргээс Эрүүл мэндийн даатгалын санд учирсан нийт 5.7 сая төгрөгийг гэм буруутай хүнээс гаргуулж, нөхөн төлүүлсэн.

Харин Өмчлөх эрхийн эсрэг 7 гэмт хэрэг үйлдэгдэж, нийт 9.8 сая төгрөгийн хохирол учирсныг бүрэн төлүүлж шийдвэрлүүлсэн байна.

Баар, цэнгээний газруудад ямар төрлийн зөрчил түгээмэл үйлдэгдэж байна вэ? Хийсэн шалгалтаар ямар нөхцөл байдал тогтоогдсон бэ?

Дээрх шөнийн цэнгээний газруудад шалгалтын ажиллагаа явуулахад “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажилладаггүй, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилсан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хийдэггүй, шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулаагүй зэрэг худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмыг зөрчих зөрчлүүд илэрсэн. Мөн “Галын аюулгүй байдлын дүрэм” байхгүйн улмаас түүнийг хэрэгжүүлж ажилладаггүй болохыг тогтоосон. Мөн хоёр газрын үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөлтэй нийцээгүй зэрэг Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг зөрчсөн нөхцөл байдал тогтоогдсон.

Шалгалтын мөрөөр авч буй арга хэмжээний талаар мэдээлэл өгөхгүй юу?

Эхний ээлжинд зөрчил гаргасан нэр бүхий шөнийн цэнгээний газруудад Прокурорын тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар прокурорын мэдэгдэл хүргүүлээд байна.

Мөн гэмт хэрэг, зөрчил удаа дараа үйлдэгдэж буй баар, шөнийн цэнгээний газруудын тусгай зөвшөөрлийг цуцлах, энэ талаар шаардлагатай арга хэмжээг авах, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-аар тогтоосон зөвшөөрөл олгох шаардлага, шалгуурыг илүү нарийвчлан тогтоох шаардлагатай гэж үзсэн тул өөрчлөлт оруулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэх зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/820